1925
УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ
14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2024.12.10 № 4/1926
танай 2024.11.28-ны № 2/4980-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
БОДЛОГЫН ГАЗАРТ

Тайлан хүргүүлэх тухай

2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 2/4980 тоот албан бичгийн дагуу Эрүүл мэндийн яамны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөлийн баталсан “Жендэрийн салбар зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг хүргүүлж байна.

Хавсралт 8 хуудастай.

ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ О.ЧОЙДОГ

АТА9996 90771?
9023050128

142240006

# УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН ТАЙЛАН

| № | Үйл ажиллагаа | Хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Зорилтот түвшин | Хамтран ажиллах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилго 1 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги төлөвлөгөө | | | | | | |
| Зорилт 1.1 Эрүүл идэвхитэй амьдрах тэгш боломж бүрдүүлж, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгана. | | | | | | |
| ЖЭТБХСДС 1.1.1. Эрүүл мэндийн салбарын жендэрийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, эрүүл идэвхтэй амьдралын мэдлэг, хандлага, дадлыг жендэрийн мэдрэмжтэй хэвшүүлэх чадавх бүрдүүлнэ | | | | | | |
| 1 | Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрүүл аж төрөх зөв дадлыг ухуулан таниулах, амьдралын зөв дадал хэвшлийг хэвшүүлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг цахим орчинд түгээх | | Арга хэмжээ | Тоо | 5 | НЭМҮТ<br>Бүх эрүүл мэндийн байгууллага |

УНТЭ-ийн УАТ-ийн эмч П.Мягмарсүрэн нь Жендэрийн үндэсний хорооны сургагч багш бөгөөд 2024.05.14-ны өдөр Жендэрийн үндэсний хорооноос бэлтгэн хүргэж буй “Хуваалцъя” ярилцлага нэвтрүүлэгт оролцож “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал” сэдвээр ярилцаж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



*Зураг 1. Ярилцлагын явцаас*

УНТЭ нь АПУ ХК-ны хамтын ажиллагааны хүрээнд эрэгтэйчүүд олноор ажилладаг Апу Трэйдинг ХХК-ны түгээлтийн жолооч нарт 2024.03.12-2024.03.13 өдрүүдэд НЭМА-ны сэтгэц, сэтгэл заслын эмч А.Оюунжаргал "Стрессээ менежмент", "Стрессийн шалтгаант хямрал", хоолзүйч Э.Санчир "Хооллолтын илчлэг тооцох арга, ажлын байрны онцлог хооллолт, стрессийн үеийн хоол шим тэжээл" сэдвүүдээр танхимын сургалт зохион байгуулсан сургалтанд нийтдээ 70 гаруй түгээлтийн ажилтан, жолооч нар хамрагдсан. Сургалтын төгсгөлд ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих цуврал контентод оролцсон.



*Зураг 2. Контентод яриа өгөх явцаас*

ЭМЯ-наас 2024.03.20-ны өдөр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн хэрэгцээ, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжтэй холбоотой саад, бэрхшээлийг тодорхойлсон хэвлэлийн тойм судалгаа"-г танилцуулах уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд УНТЭ-с УАТ-ын эмч П.Мягмарсүрэн, НЭМА-ны мэргэжилтэн О.Чанцалдулам нар оролцож эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал, дундаж наслалтын зөрүүг арилгах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийн талаар санал бодлоо солилцсон.
Жендэрийн үндэсний хорооноос 2024.10.22-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулах уулзалт зохион байгуулсан бөгөөд УНТЭ-с НЭМА-ны дарга Г.Алтанцоо оролцож эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал, дундаж наслалтын зөрүүг арилгах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийн талаар санал бодлоо хүргүүлсэн.

ЖЭТБХСДС 1.1.5 Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүтэй байдал, түүний шалтгааныг газарзүйн байршлаар нарийвчлан судалж, орон нутгийн төлөвлөгөөнд тусгана

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Эрэгтэйчүүдийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, нөлөөллийн ажлыг орчин үеийн анагаах ухааны онолын хүрээнд боловсруулах | | Судалгааны арга аргачлалын төслийг боловсруулсан эсэх | Тийм/ Үгүй | 1 | НЭМҮТ УНТЭ |
| Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 13-р зүйлийн 13.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2020 оны 07 сарын 01-ний өдрийн дугаар 99-р захирамжаар батлагдсан “Эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.3 дахь заалтын хүрээнд төрөөс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээ бий болгох зорилгын дор УНТЭ-ийн Урологи Андрологийн төв нь ‘Эрэгтэйчүүдийн кабинетын үлгэрчилсэн загвар, ажиллах журам батлах тухай тушаалыг боловсруулсан бөгөөд уг журмыг ЭМС-ын 2022 оын 09 сарын 05 өдрийн А/449 тоот тушаалаар батлуулсан бөгөөд уг журмын дагуу эрэгтэйчүүдэд андрологийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.<br>УНТЭ-ийн Урологи андрологийн төвийн эмч нар Түрүү булчирхайн хоргүй хавдрын оношилгоо эмчилгээ, Бөөрний чулууны оношилгоо, эмчилгээний стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байгаа бөгөөд боловсруулсан стандартыг ЭМЯ-ны Урологи – Андрологийн салбар зөвлөл руу хяналт хийлгэхээр хүргүүлэн ажиллаж байна. | | | | | | |
| ЖЭТБХСДС 1.5.13 Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах | | | | | | |
| 3 | Хүчирхийлэлийн эсрэг 16 хоногийн аянд нэгдэх, урьдчилан сэргийлэх, нөлөөллийн ажлыг зохион байгуулах | | Арга хэмжээ | Тоо | 1 | ГССҮТ<br>Бүх эрүүл мэндийн байгууллага |
| 2024.03.01-2024.04.01-ний хугацаанд Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээнд “Харилцан хүндэтгэж тэгш оролцоог хангая” уриатайгаар зохион байгуулсан “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ” нэг сарын аянд "Улсын Нэгдүгээр төв Эмнэлэг"-ийн хамт олон нэгдэж хамтарч ажилласан. | | | | | | |




*Зураг 3. Аяны уриа зураг*

Жендэрт суурилсан хүчирхийллийн (ЖСХ) эсрэг 16 хоногийн аян нь жил бүрийн 11-р сарын 25-наас 12-р сарын 10-ны хооронд тохиодог бөгөөд Манай улсад 1997 оноос эхлэн Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвөөс анх энэхүү аяныг зохион байгуулан эхлүүлж, түүнээс хойш НҮБ-ын Хүн амын сан, Засгийн газрын байгууллагууд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, хөгжлийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд нэгдэж Монгол улсад Жендэрт суурилсан хүчирхийллийг аяныг зохион байгуулан ажилладаг. 2024 оны дэлхий нийтийн дэвшүүлж буй уриа нь “Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход нэгдье” бөгөөд Монгол Улс “ОХИД ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА Ч АЮУЛГҮЙ-Шалтаг бүү тооч” нэрийн дор аяныг зохион байгуулж байна. Тус аяны нээлтэнд УНТЭ-ийн НЭМА-ны дарга Г.Алтанцоо, мэргэжилтэн Д.Гандулам нар оролцсон.

УНТЭ тус аянд нэгдэж, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна. НЭМА-ны дарга Г.Алтанцоо байгууллагын эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан нарт “ Охид , эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход нэгдье “ мэдээлэл хийж , хүчирхийллийн эсрэг аянд нэгдэхийг уриаллаа.



*Зураг 4. Нээлтийн явцаас*



*Зураг 5. Үйл ажиллагааны явцаас*

2024 оны 12 сарны 3-ны өдөр Жендэрийн үндэсний хороотой хамтран Олон нийтийн жендерийн боловсрол, соён гэгээрүүлэх асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Бямбадорж нийт сувилагч нарт " ЖСХТэмцэх аян " сэдвээр сургалтыг амжилттай зохион байгуулсан.



*Зураг 6. Сургалтын явцаас*

ЭМЯ, НЭМҮТ, ДЭМБ, Жэндэрийн үндэсний хороо, Хүний эрхийн үндэсний коммисс болон мэргэжлийн байгууллагууд хамтран боловсруулсан мэдээлэл түгээх контентүүдийг ашиглан Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэгийн байгууллагын албан ёсны мэдээллийн сувгууд болох цахим фэйсбүүк фэйж хуудас, хамт олны групп, гадаад дотоод вэбсайтдаа байршуулж мэдээ мэдээлэл,зөвлөмжүүдийг тогтмол байршуулан ажиллаж байна.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| <br>*Зураг 7. Мэдээлэл байршуулсан явцаас* | | | | | |
| 4 | ХЗБХ-ний үүрэг даалгавар:<br>Эрүүгийн хуулиас ажлын байран дээрх бэлгийн дарамт үзүүлсэн тохиолдолд ял хүлээлгэх тухай зүйл, заалтыг хассан нь салбар дахь АББД-ын нөхцөл байдалд ямар нөлөө үзүүлснийг судлах | | Судалгаанд хамрагдсан байгууллага | тоо | 10 | НЭМҮТ<br>Бүх нийтийн эрүүл мэндийн байгууллага |
| УНТЭ нь Ерөнхий захирлын 2022 оны А/246 тоот тушаалын дагуу нийт ажилтнуудын “Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой мэдээлэл, гомдол гаргах процессын зураглал, ажлын байрны бэлгийн дарамтын талаарх мэдлэг, ойлголтыг тандах, урьдчилан сэргийлэх санал асуулгын хуудасны загвараар судалгаа авч судалгааны дүгнэлтэнд тулгуурлан арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна, холбогдох сургалтын хөтөлбөрийн загвар, “Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ”-нд ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх заалт тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | | | | | |




*Зураг 8. Баталсан журам, судалгааны явцаас*

ЖЭТБХСДС 3.2.3 ЭМСЖЭТБХТ 2.2.2.3 Жендэрийн цахим сургалтыг зохион байгуулах

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | Удирдах ажилтнуудад зориулсан цахим сургалтыг явуулж, гэрчилгээжүүлэх | | Сургалт явагдсан байна | тоо | 45 | НЭМҮТ<br>Бүх нийтийн эрүүл мэндийн байгууллага |

2024.09.13-ны өдөр Жендэрийн үндэсний хороотой хамтран Хүний эрхийн боловсрол хариуцсан референт О.Тодбулаг "Хүний эрхийн ойлголт, хууль эрхзүй" сэдвээр дэмжих үйлчилгээний ажилтнуудад сургалтыг амжилттай зохион байгуулсан.



*Зураг 9. Сургалтын явцаас*

2024.04.05-ны өдөр Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэсийн мөрдөн байцаагч, ахлах дэслэгч Т.Баясгалантай

хамтран “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” түүнээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” сэдвээр УНТЭ-ийн дэмжих үйлчилгээний 245 ажилтануудад сургалтыг амжилттай зохион байгууллаа.




*Зураг 10. Сургалтын явцаас*

2024.04.16-ны өдөр Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэсийн мөрдөн байцаагч Н.Сугарганболдтой хамтран “Эрүүл мэндийн салбарт үйлдэгдэж буй гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” сэдвээр УНТЭ-ийн нийт сувилагч, тусгай мэргэжилтэнгүүдэд /300/ сургалтыг амжилттай зохион байгууллаа.



*Зураг 11 . Сургалтын явцаас*

Тайлан хянасан: НЭМА-ны дарга Г.Алтанцоо

Тайлан боловсруулсан:НЭМА-ны мэргэжилтэн Д.Гандулам